

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 11 ДУГААР САРЫН 02 ДАХЬ  
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ**

2017.11.09

	Хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрэний хүрээнд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний орон нутгийн төсөв санхүүгээр хийгдсэн булаг шандны эхийг хамгаалах, тарваганы нөөц тогтоох, судалгаа хийх. Толбо чиглэлийн хар зам дагуу ойжуулалтын услын систем тавих, хууль бус ашиглалтад хяналт тавих ажилуудыг гүйцэтгэлүүдийг аймгийн Засаг даргын А/496 дугаар захирамжаар байгуулсан ажлын Комисс хүлээн авч, үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлэх ажлыг гүйцэтгэв.		
2	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллыг нэгтгэж байна.		
3	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг орон нутгийн телевизээр сурталчилах ажлыг зохион байгууллаа.		
4			

**ӨНГӨРСӨН ДОЛООН ХОНОГТ БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ӨГСӨН  
ҮҮРЭГ ДААЛГАВЫН БИЕЛЭЛТ**

БОАЖЯам болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран “Хавх булаагүй ууланд хамаг амьтан жаргалтай” сарын аянд Баяннуур, Булган, Өлгий сумдын байгаль хамгаалагч нар идэвхтэй оролцож 330 ширхэг хавх цуглуулж, Улсад 1-р байранд шалгаран 3 байгаль хамгаалагчийг гурван мотоциклээр шагнагдлаа.



Жил бүр тэмдэглдэг “Дэлхийн цоохор ирвэс хамгаалах” өдөр энэ жил Увс аймагт зохион байгуулсан манай аймгаас 60 сурагч, 6 багш, 5 мэргэжилтэнг оролцов. Манай аймгийн сурагчид тэмцэнд оролцож 2 дугаар байрт шалгарсан.

Манай аймгийн Алтай Сумын “Халуун бардам” Агнуурын бүс нутаг, Булган сумын “Улаагчин” агнуурын бүс нутгуудын менежментийг хариуцаж байгаа Лүүк Монголия ХХК-д тус сумын байгаль хамгаалагч нарыг унаатай болгох санал тавьж Булган сумын Улаагчин нөхөлөлийг УАЗ 469 машинтай Алтай сумын 2 байгал хамгаалагчийг 2 ширхэг мотоциклтэй болгосон. Цашид тусгай зориулалтаар ан агнуулсан Бугат, Булган, Алтай, Буянт, Улаанхус, Дэлүүн, Толбо сумуудын байгаль хамгаалагчидыг Унаатай болгох, өвлийн дүрэмт хувцасаар хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



Алтанцөгц сумын “Мундуйн дэвсэг”, Баяннуур сумын “Уушигийн улаан”, Цэнгэл сумын “Мухар”, Улаанхус сумын “Баянзүрх”, Дэлүүн сумын “Улаан говь”, Булган сумын “Улаагчин”, Ногооннуур сумын “Борт”, “Бахлаг”, “Модон овоо”, Бугат сумын “Тошинг-Хатуугийн гол” агнуурын бүс нутагуудад ан амьтны мэргэжлийн байгуулагад нарийвчилсан агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг

хийлгэж БОАЖЯамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүллээ.

“Бүргэдийн баяр-2017” наадам эвэнт арга хэмжээг аймгийн Засаг даргын 2017 оны А/525 тоот захирамжаар байгуулагдсан, наадмын комисстой хамтран зохион байгуулж, наадмыг тохиолдуулан 2 өдрийг хоггүй ажиллах уриа доор 400 ширхэг хогийн уутыг хүүхдүүд болон үйлчилгээ явуулсан иргэдийн дунд тараан өгч, хог түүж цуглуулж ирсэн хүмүүст нийт 200 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал үзүүлэв. Нийт 2 өдөрт 2 портер хогийг цэвэрлүүлэн хогийн цэгт хүргүүллээ.



Намрын бүх нийтээр мод тарих өдөрлөгийг сумдын ЗДТГ, СДО ангитай хамтран зохион байгууллаа. Намар, хаврын мод тарих өдөрлөгөөр 12 төрлийн 42072 ширхэг мод, бут сөөг таригдсан.

Аймгийн хэмжээний уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын тооллогыг аймгийн ЗДТГазар, ГХБХБ-ын газартай хамтран зохион байгуулж, тооллогын нэгдсэн дүнг БОАЖЯаманд хүргүүлэв.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**